

Улсын төсвийн газрын
Төрийн аудитын газар



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч
талуудын оролцоог сайжруулах жил*

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2024 оны
жилийн эцсийн

АГУУЛГА.....	2
Товчилсон үгийн тайлбар.....	3
БҮЛЭГ 1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	5
1.1 Бүтэц, зохион байгуулалт.....	5
1.2 Аудитын үйл ажиллагаа.....	7
БҮЛЭГ 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	9
2.1 Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн	11
2.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл.....	11
2.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого чиглэл.....	12
2.4 Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө	12
2.5 ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит	12
2.6 Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит.....	14
2.7 Санхүүгийн тайлангийн завсрын аудит.....	14
БҮЛЭГ 3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	14
3.1 Гүйцэтгэлийн аудитын үр дүн	16
3.2 Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө	16
3.3 Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн ..	16
3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө.....	17
3.5 Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн.....	18
3.6 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн.....	18
3.7 Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө.....	19
БҮЛЭГ 4. НИЙЦЛИЙН АУДИТ	20
4.1 Нийцлийн аудитын үр дүн	22
4.2 Нийцлийн аудитын үр нөлөө	22
4.3 Аймаг, нийслэл, сум дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох.....	22
4.4 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах.....	22
4.5 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах.....	24
4.6 Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын Гүйцэтгэлд хийх аудит.....	24
4.7 Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх	25
4.8 Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит.....	25
4.9 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх.....	26
БҮЛЭГ 5. ДОТООД АЖИЛ	27
5.1 Сургалт.....	27
5.2 Хамтын ажиллагаа	28
5.3 Мэдээлэл сурталчилгаа	30
5.4 Албан харилцаа.....	32
5.5 Өргөдөл гомдол	32

5.6 Нууцын хадгалалт хамгаалалт	33
5.7 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх.....	33
5.8 Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд.....	34
5.9 Мэдээллийн технологи.....	35

БҮЛЭГ 6. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	35
--	----

БҮЛЭГ 7. ДҮГНЭЛТ	36
------------------------	----

БҮЛЭГ 8. ШИНЭ САНААЧИЛГА	37
--------------------------------	----

БҮЛЭГ 9. САНАЛ.....	39
---------------------	----

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
АШУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Их сургууль
АНУЗГ	Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газар
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
ХБТГ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар
СНАГ	Санхүү-нийцлийн аудитын газар
ЧБГ	Чанарын баталгаажуулалтын газар
ДАХШҮГ	Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар
МТТ	Мэдээллийн технологийн төв
ЗХЭЗГ	Захиргаа, хууль, эрх зүйн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ДАДТАГ	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТАХ	Төсөл арга хэмжээ
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МТ	Мэдээллийн технологи
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУИС	Монгол Улсын Их сургууль
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч

1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилтыг "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" гэж тодорхойлсны дагуу 4 зорилт, 11 дэд зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаж 2024 онд гүйцэтгэсэн аудит бүрд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ын дагуу аудитын үе шат бүрд чанарын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллалаа.

1.1 Бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/51 дүгээр тушаалаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн "Зохион байгуулалтын бүтэц батлах тухай" 2024.11.18-ны өдрийн А/17 дугаар тушаалаар үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон дэмжих үйлчилгээний нэгжийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Схем №1. “Газрын бүтэц, зохион байгуулалт”



Тайлант онд хүний нөөцийн асуудалтай холбоотой дараах арга хэмжээг авч ажиллалаа.

Үүнд:

- Хариуцсан ажилдаа амжилт гаргасан 2 албан хаагчдад 2024.06.21-ний өдрийн Б/20 тушаалаар үндсэн цалингийн 80-100 хувиар урамшуулал олгосон.
- МУЕА-ын 2024.05.29-ний өдрийн Б/90 дүгээр тушаалаар 2 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлж шийдвэрлүүлсэн.
- Шинжээчийн тусгай шалгалтад тэнцсэн жолооч, нярвыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалж, “Ажлаас чөлөөлөх тухай” 2024.11.01-ний өдрийн Б/14 дугаартай тушаалаар баталгаажуулсан.


- “Ажилд томилох тухай” 2024.11.08-ны Б/15 дугаартай тушаалаар жолооч, нярвыг томилж ажилласан.
- ТАБ-ын шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөрийн 2.2.1.1-д заасны дагуу “Дадлагажуулагч томилох тухай” 2024.11.08-ны Б/15 дугаартай тушаалыг баталсан.
- ТАБ-ын хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 13 албан хаагчдад 13 хоногийн цалинтай, 41 хоногийн цалингүй чөлөө өгч, 1 албан хаагчийг эчнээ сургалтад хамрагдах хугацаанд цахимаар ажиллах гэрээ байгуулж ажилласан.
- Тэмдэглэлт ойг тохиолдуулан хариуцсан ажилдаа амжилт гаргасан 4 албан хаагчийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, 1 албан хаагчийг төрийн хяналтын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 1 албан хаагчийг Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ээр, 1 албан хаагчийг “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 2 албан хаагчийг аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр тус тус шагнуулахаар холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлсэн.

1.2 Аудитын үйл ажиллагаа

Төрийн аудитын газар нь 2024 онд 242 аудитыг гүйцэтгэж, үүнээс Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төсөв захирагчдын төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 103 бие даасан дүгнэлт гаргаж, 127 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Гүйцэтгэлийн 5 аудитад 250, нийцлийн 7 аудитад 303 шалгагдагч этгээдийн үйл ажиллагааг тус тус хамруулж ажиллалаа.

Дүрслэл 1. Гүйцэтгэсэн аудит /тоо/


Дүрслэл 2. Аудитын илрүүлэлт /сая.төг/



Гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт 117,856.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, нийт 274.9 сая төгрөгийн зөрчилд 64 төлбөрийн акт тогтоож, 37,264.0 сая төгрөгийн зөрчилд 168 албан шаардлага, 25,942.4 сая төгрөгийн зөрчилд 295 зөвлөмж, 141.3 сая төгрөгийн 13 сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 2 ширхэг 1,186.1 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилж ажиллалаа.

Тайлант онд 36,762.6 сая төгрөгийн 182 санхүүгийн, 16 санхүүгийн бус үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 37.5 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.0 төгрөгөөр буюу 59.6 хувиар өссөн байна.

Дүрслэл 3. Аудитын үр нөлөө



Төлбөрийн акт: Оны эхэнд 103.6 сая төгрөгийн 11 төлбөрийн актын үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 274.9 сая төгрөгийн 64 төлбөрийн акт тогтоож, 352.5 сая төгрөгийн 65 төлбөрийн актыг төсөвт төвлөрүүлж 5.1 сая төгрөгийн 5 хугацаа болоогүй, 20.9 сая төгрөгийн 5 хугацаа хэтэрсэн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Албан шаардлага: Оны эхэнд 8,843.4 сая төгрөгийн 35 албан шаардлагын үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 37,264.0 сая төгрөгийн 168 албан шаардлага хүргүүлж, 45,631.4 сая төгрөгийн 195 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, тайлант оны хугацаа болоогүй 476.0 сая төгрөгийн 8 албан шаардлагын үлдэгдэлтэй байна. Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь биелүүлээгүй 8 төсвийн шууд захирагч, 3 төсвийн төвлөрүүлэн захирагч, 2 төрийн болон орон нутгийн өмчит газрын удирдлагуудад 141.3 сая төгрөгийн 13 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг 100 хувь хангуулж ажиллалаа.

Зөвлөмж: Оны эхэнд 5,391.3 сая төгрөгийн 58 зөвлөмжийн үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 25,942.4 сая төгрөгийн 295 зөвлөмж өгч, 15,592.5 сая төгрөгийн 323 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, тайлант оны хугацаа болоогүй 15,804.2 сая төгрөгийн 30 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд ТБХ-ны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын сэдэв батлах тухай" 2023 оны А/75, А/160 дугаар тушаал, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавар, "Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл", Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны "Бодлого, чиглэл батлах тухай" А/59, "Заавар батлах тухай" А/89 дугаар тушаалын дагуу 100 хувь гүйцэтгэж, 468 хүн/ өдөр зарцуулан ажиллалаа.


Санхүүгийн тайлангийн аудитаар 2024 онд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг 2024.04.26-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталгаажууллаа. Санхүүгийн тайлангийн аудитаар 15,392.4 сая төгрөгийн 134 санхүүгийн үр өгөөж, 2 санхүүгийн бус үр өгөөж бүртгэж ажиллалаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хамрагдсан байгууллага 230



Аудитын санал дүгнэлт 103



Аудитын нийт илрүүлэлт – 96,388.1 сая төгрөг

Залруулсан -53,047.3 сая төгрөг

Залруулагдаагүй – 43,340.8 сая төгрөг



- Төлбөрийн акт - 202.1 сая төгрөг
- Албан шаардлага - 32,321.1 сая төгрөг
- Зөвлөмж 10,138.2 сая төгрөг
- Хариуцлага тооцуулах -141.3 сая төгрөг
- Хууль, хяналтын байгуулагад шилжүүлсэн -538.1 сая төгрөг



202.1 сая/төг
сая/төг
Акт



32,321.1 сая/төг
Албан шаардлага



10,138.2
Зөвлөмж

Эхний үлдэгдэл	Тайлант онд тогтоосон	Хэрэгжсэн	Хуулийн байгууллагад шилжүүлсэн	Үлдэгдэл
		Сая төгрөгөөр		
17.4	202.1	Акт		198.6
				20.9
28.3	32,321.1	Албан шаардлага		32,349.4
0.0	141.3	Хариуцлага тооцуулах		141.3
0.0	10,138.2	Зөвлөмж		10,138.2

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 4-р улирлын статистик мэдээ

2.1 Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн

Тайлант онд хуулиар тогтоосон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, төсөл хөтөлбөрийн нийт 230 шалгагдагч байгууллагаас 103 байгууллагад аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж, 127 байгууллагыг түүвэрт хамруулан санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж ажиллалаа. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч - 1
- Төсвийн төвлөрүүлэн захирагч - 14
- Төсвийн шууд захирагч – 191
- Төрийн болон орон нутгийн өмчит - 24

Санхүүгийн тайлангийн аудитаар 103 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 99 буюу 96.2 хувьд “Зөрчилгүй”, 2 буюу 2.0 хувьд “Хязгаарлалттай”, 1 буюу 0.9 хувьд “Сөрөг”, 1 буюу 0.9 хувьд нь “Татгалзсан” санал дүгнэлт өгч ажиллалаа.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 96,388.1 сая төгрөгийн 506 алдаа, зөрчил илэрснээс, 53,047.3 сая төгрөгийн 124 алдааг аудитын явцад залруулж, 202.1 сая төгрөгийн 51 төлбөрийн акт, 32,321.1 сая төгрөгийн 138 албан шаардлага, 10,138.2 сая төгрөгийн 179 зөвлөмж, өмнөх оны аудитын шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй 13 байгууллагын удирдлагуудад 141.3 сая төгрөгийн 13 хариуцлага тооцуулах албан шаардлага, тендерийн болон тендерийн бус 538.1 сая төгрөгийн худалдан авалтад ашиг сонирхлын зөрчилтэй болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий аудиторт 2024.06.05-ны өдрийн 364 дүгээр албан бичгээр уламжилж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газарт хүргүүлж ажилласан.

Төлбөрийн акт:

Өмнөх оноос шилжин ирсэн 17.4 сая төгрөгийн 8, тайлант хугацааны 202.1 сая төгрөгийн 51 төлбөрийн актаас 198.6 сая төгрөгийн 54 төлбөрийн актыг төсөвт төвлөрүүлэн хугацаа хэтэрсэн 20.9 сая төгрөгийн 5 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Албан шаардлага:

Өмнөх оноос шилжин ирсэн 28.3 сая төгрөгийн 2, тайлант хугацааны 32,321.1 сая төгрөгийн 138 албан шаардлагын биелэлтийг 100 хувь хангуулж ажилласан.

Зөвлөмж:

Шалгагдагч байгууллагууд Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллалаа. Тайлант хугацааны 10,138.2 сая төгрөгийн 179 зөвлөмжийн биелэлтийг 100 хувь хангуулж ажилласан.

2.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого чиглэл

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг, А/89 дүгээр тушаалаар

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу 73 заалтаас шалгадагч байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай заалтын хэрэгжилтэд аудитын горим сорил хэрэгжүүлэн нийт 3,315.8 сая төгрөгийн 80 зөрчил илэрснээс, 48.4 сая төгрөгийн 13 төлбөрийн акт тогтоон, 3,218.4 сая төгрөгийн 18 албан шаардлага, 49.0 сая төгрөгийн 49 зөвлөмж өгч хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажилласан.

2.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого чиглэл

Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан ангилалд хамаарах 191 төсөвт байгууллага, 24 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсвийн төвлөрүүлэн захирагч 14, төсвийн ерөнхийлөн захирагч 1, нийт 230 байгууллагад АДБОУС 4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/71 дугаар тушаалаар батлагдсан “Заавар, аргачлал батлах тухай”, 2021 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллага шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд аудит хийх аргачлал”-ын дагуу Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг цахим хуудсанд бүрэн байршуулсан эсэхийг анхан шатны баримт материалтай нь тулган шалгах горим сорил хэрэгжүүлэн ажилласан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,551.7 сая төгрөгийн 29 зөрчил илэрсэнд, мэдээллийг нөхөн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,551.7 сая төгрөгийн 8 албан шаардлага, мэдээллийг хуульд заасан хугацаанд нь байршуулж байх 21 зөвлөмж өгч ажиллалаа. Мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн аудитаар 2, " Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар 1 албан шаардлагыг иргэд, олон нийтэд санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх талаар, "Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар авто замын сангийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээллийг мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх, шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээлэх талаар 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Тайлант оны жилийн эцсийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тайланг 2024.12.05-ны өдрийн 659 дугаартай албан бичгээр Эрсдэлийн удирдлагын газрын захирал Д.Отгонбаярт хүргүүлж ажиллалаа.

2.4 Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө

Жил бүр орон нутаг дахь бүх шатны төсөв захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан тухайн жилийн аудитын багийн бүрэлдэхүүн, аудитаар баримталсан бодлого, чиглэл, аудитын үр дүнг танилцуулж хэвшсэнээр шалгадагч байгууллагуудын аудитын үйл ажиллагаанд оролцох хариуцлага, хандлага төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч ирсэн. Харин тайлант онд ДБЭХС ТӨХК-д санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх болсноор материаллаг шинж чанартай алдаа зөрчил өмнөх оноос нэмэгдсэн.

2.5 Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит


Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТЕЗ-ийн хамрах хүрээний 96 байгууллагыг 100 хувь хамруулан, 35 байгууллагад бие даасан санал,

дүгнэлт өгч, 61 байгууллагыг түүвэрт хамруулан, Өөрчлөлтгүй санал дүгнэлт өгч ажиллалаа.

Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд ТБХ-ны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Аудитын сэдэв батлах тухай" 2023 оны А/75, А/160 дугаар тушаал, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, заавар, "Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл", Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны "Бодлого, чиглэл батлах тухай" А/59, "Заавар батлах тухай" А/89 дугаар тушаалын дагуу гүйцэтгэж Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 643.7 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 2.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 641.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгч ажилласан.



ОНТЕЗ-ийн нийт 238 алдаа, зөрчил
20,907.0 сая төгрөг



Аудитаар нийт 20,907.0 сая төгрөгийн 238 алдаа, зөрчил илрүүлснээс 7,418.3 сая төгрөгийн 56 алдааг залруулж, 132,7 сая төгрөгийн зөрчилд 19 төлбөрийн акт тогтоож, 9,650.7 сая төгрөгийн зөрчилд 80 албан шаардлага, 3,590.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 74 зөвлөмж, 114.8 сая төгрөгийн зөрчилд 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 9 албан шаардлагыг тус тус хүргүүлэн ажилласан. Үүнд:

Санхүүгийн тайлагналтай холбоотой: 131.1 сая төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 4,678.7 сая төгрөгийн зөрчилд 58 албан шаардлага, 619.2 сая төгрөгийн зөрчилд 32 зөвлөмж, 114.8 сая төгрөгийн зөрчилд 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Нийцлийн аудиттай холбоотой: 1.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,972.0 сая төгрөгийн зөрчилд 22

албан шаардлага, 2,971.3 сая төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өгч ажилласан.

2.6 Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан нийт орлого ба тусламжийн 88,613.1 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн 77,330.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж дүгнэлт гарган ажилласан.

Аудитад 4.5 сая төгрөгийн өртөг, 42 хүн/өдөр зарцуулан, баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь очиж үзэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэрэг горимуудыг хэрэгжүүлэн, нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 11,388.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 8,444.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2,943.8 сая төгрөгийн 3 зөвлөмж, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах 2 саналыг ҮАГ-т уламжилж ажиллалаа.



Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн аж ахуйн нэгжүүд нь орлогын албан татварыг оны эцэст төвлөрүүлсэн хэдий ч дахин хуваарилалтыг холбогдох журмын дагуу дараа сард хийдгээс шалтгаалж орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас олгох 1,118.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосноос ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн бүрэн хангагдаагүй байна гэж дүгнэлээ.

Аудитын тайланг 2024.04.26-ны өдрийн А/04 дугаар тушаалаар баталгаажуулж, ҮАГ-ын СНАГ, аймгийн ИТХ, Засаг дарга нарт хүргүүлж, иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn болон open.audit.mn сайтад тус тус байршуулж ажилласан.

2.7 Санхүүгийн тайлангийн завсрын аудит

Төрийн аудитын тухай хуулийн бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.5, 2021 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын 3.12 дахь заалтуудыг үндэслэн төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн завсрын аудитыг санхүүгийн тайлангийн Fas программаар гүйцэтгэлээ.

Завсрын аудитад төсвийн шууд захирагчийн 26, төрийн болон орон нутгийн өмчит 4 байгууллагыг хамруулан 3,318.0 сая төгрөгийн 58 алдаа, зөрчил илрүүлэн 4.0 сая төгрөгийн 1 алдааг залруулан, 5,1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 328,6 сая төгрөгийн 4 албан шаардлага, 2,980.3 сая төгрөгийн 50 зөвлөмж өгч шалгагдагч этгээдэд асуудлын бүртгэлийг танилцуулан баталгаажуулж ажилласан.

3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь 2024 онд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн байнгын хорооны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын

“Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаал, АДБОУС түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан заавар, журам, ТАБ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн холбогдох байгууллагуудаас аудитад шаардагдах судалгаа, мэдээлэл гаргуулан авч, ирүүлсэн нотлох зүйл, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”, “Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” зэрэг нийт 5 гүйцэтгэлийн аудитад 250 байгууллагыг хамруулан 115.3 сая төгрөгийн өртөг, 359 хүн/өдөр зарцуулсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ





5

Аудит гүйцэтгэсэн



250

Байгууллагыг хамруулсан



Тайлбар: Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо - мөнгөн дүн /сая.төг/ гэсэн дарааллаар харна.

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны жилийн эцсийн статистик мэдээ

3.1 Гүйцэтгэлийн аудитын үр дүн

Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө, авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө, хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад тулгуурлан тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитаар тайлант онд нийт 15,427.9 сая төгрөгийн 151 зөрчил илрүүлж, 72.8 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт, 4,942.9 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага, 9,764.2 сая төгрөгийн зөрчилд 110 зөвлөмж өгч, ашиг сонирхлын зөрчилтэй болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн 648.0 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг тайланд тусгаж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газарт хүргүүлж ажилласан.

Гүйцэтгэлийн аудитаар 111.9 сая төгрөгийн 10 төлбөрийн акт, 4,471.5 сая төгрөгийн 24 албан шаардлага, 5,391.3 сая төгрөгийн 94 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, хугацаа болоогүй 5.1 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 476.0 сая төгрөгийн 6 албан шаардлага, 9,764.2 сая төгрөгийн 25 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

3.2 Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө

Батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”, “Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-нд тус тус гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад үндэслэн тайлагнаж, дүгнэлт, зөвлөмж, саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитаар 12,308.3 сая төгрөгийн 27 санхүүгийн, 14 санхүүгийн бус үр өгөөжийг шалгадагч этгээдээр хүлээн зөвшөөрүүлж ажиллалаа.

3.3 Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын дүн



10,442.2 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага **30.0** сая төгрөг
Зөвлөмж **9,764.2** сая төгрөг
Хяналтын байгууллагад **648.0** сая төгрөг

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийх аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 25-аас 05 дугаар сарын 16-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

УТХО-аар хийгдэх ТАХ-ний төсөвт өртөг нь нэмэгдсэнээс шалтгаалж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд дуусаагүй байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бага дүнтэй төсөл, арга хэмжээг он дамжуулах, улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх, зураг, төсөвт тавигдах шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөж зарцуулсан байна.

Аудитаар хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанаас хоцроох, он дамжуулан хойшлуулах нийтлэг зөрчил илэрч байгаад төлөвлөлтийн хангалтгүй байдал нөлөөлж байна гэж дүгнэлээ.

Аудитын тайланг 2024.05.16-ны өдрийн А/06 дугаар тушаалаар баталгаажуулж, мөн өдрийн албан бичгээр УАГ-ын ГНАГ, аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, ГХБХБГ, ОНӨГ-т тус тус хүргүүлж ажиллалаа.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг <https://open.audit.mn/>, audit.mn сайтад байршуулсан.

3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

	6,019.0 сая төгрөг Илрүүлсэн алдаа ЗӨРЧИЛ		Аудитын дүн Төлбөрийн акт 67.7 сая төгрөг Албан шаардлага 4,466.9 сая төгрөг Зөвлөмж 1,484.4 сая төгрөг

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийх аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан аудитыг 2024 оны 05 дугаар сарын 21-ээс 06 дугаар сарын 26-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөхдөө холбогдох хууль журамд заасны дагуу иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 88.0 хувьтай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хэрэгжилтэд тавих ИТХ-ын хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, хяналтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна гэж дүгнэлээ.



Аудитын тайланг 2024.07.05-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталгаажуулж, мөн өдрийн албан бичгээр Архангай аймаг дахь ТАГ-т, аймгийн Засаг даргад, ИТХ-ын даргад тус тус хүргүүлж ажилласан.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг <https://open.audit.mn/>, audit.mn сайтад байршуулсан.

3.5 Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Аудитын дүн



258.2 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага 258.2 сая төгрөг
Зөвлөмж 6

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийх аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан аудитыг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 10 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газарт гаргаж хүргүүлдэг үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-аар гаргасан мэдээгээр аймгийн хэмжээнд 2021 онд 1489 хүүхэд, 2022 онд 2399 хүүхэд, 2023 онд 7450 хүүхэд эрсдэлт нөхцөлд байна. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийхгүй, зөвхөн тохиолдол болсон үед нөхцөл байдлын үнэлгээ хийж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна.

Аудитаар хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн тайлан, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүйгээс нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үзээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын тайланг 2024.10.25-ны өдрийн А/13 дугаартай тушаалаар баталгаажуулж, мөн өдрийн албан бичгээр УАГ-ын ГНАГ, аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт тус тус хүргүүлж ажилласан.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг <https://open.audit.mn/>, audit.mn сайтад байршуулсан.

3.6 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

Аудитын дүн



187.8 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага 187.8 сая төгрөг
Зөвлөмж 4



“Авто замын сангийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 10 дугаар сарын 11-ний өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Төсвийн тухай хуулийн 29.4-д заасан зураг, төсвөө батлуулсан төсөл, арга хэмжээг батлуулсан боловч 187.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг Авто замын тухай хуулийн 19.1-д зааснаар авто зам, авто замын байгууламжийн зураг төсөв зохиох тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн нь хууль, журмын шаардлагыг хангаж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн байна. Өмнөх оноос шилжиж хэрэгжсэн 311.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдэж, комисс хүлээж аваагүй байна. Тус ажлыг 2024 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр барьж байгаа бөгөөд захиалагч байгууллагын уялдаа холбоо дутмаг байгаагаас авто замын сангийн хөрөнгийг үр ашиггүй төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна. Аудитаар нийт 187.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн зөрчил арилгуулах 187.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, хяналтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна гэж дүгнэлээ.

Аудитын тайланг 2024.10.14-ний өдрийн А/12 дугаар тушаалаар баталгаажуулж, 2024.10.17-ны өдрийн албан бичгээр аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт хүргүүлж ажилласан.

3.7 Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө



17.5 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Төлбөрийн акт 12.8 сая төгрөг
Албан шаардлага 4.7 сая төгрөг
Зөвлөмж 5

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги батлагдан гараагүй, ЗГ-аас тогтоосон бүтэц, орон тооны хязгаар нь ерөнхий байдлаар батлагдсанаас шалтгаалж, ЗДТГ-ын орон тоо харилцан адилгүй батлагдаж, хязгаараас хэтэрсэн байдалтай байна.



Хүний нөөцийн бодлогын зорилтын хэрэгжилт нь нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тасралтгүй байх зарчмыг хангахгүй байгаа бөгөөд биелэлтэд ахиц дэвшил гараагүй, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-үнэлгээг хийгээгүй, үр нөлөөг тооцохгүй байгаа нь бодлогын хэрэгжилтэд тавих хяналт сул байгааг харуулж байна.

Төрийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээнд хийсэн шинжилгээгээр төрийн захиргааны салбарын хүний нөөцийн хүрэлцээ 90.2 хувь, соёлын салбарын хүний нөөцийн хүрэлцээ 92.8 хувь, бусад салбарт 94.4-94.7 хувьтай байна.

Хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж тухайн сул орон тооны албан тушаалтны чиг үүргийг бусад төрийн албан хаагчдад давхар хариуцуулснаас ажлын ачаалал үүсэх, төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Цаашид хүний нөөцийг жигд хүртээмжтэй хуваарилахад төрийн байгууллагуудын хүний нөөцийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны жишиг нормативыг баталж мөрдүүлэх шаардлага үүссэн байна.

Төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.


Аудитаар нийт 5.1 сая төгрөгийн 25 зөрчил илэрснээс 5.1 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 12 зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга, ТАСЗ-ийн дарга нарт, 6 саналыг YAГ-аар дамжуулан Монгол Улсын Засгийн газар, ТАЗ, Боловсролын яаманд хүргүүлсэн.

Аудитаар орон нутагт төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги батлагдаагүй, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын тайланг 2024.11.20-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталгаажуулж, мөн өдрийн албан бичгээр ГНАГ, ТАЗ-ийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлд тус тус хүргүүлж ажиллалаа.

4. НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь 2024 онд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн байнгын хорооны 08 тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаал, АДБОУС түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан заавар, журам, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах” тухай 08 дугаар тогтоол, СЕХ-ны “Аргачлал батлах тухай” 2024.01.25-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Заавар аргачлал шинэчлэн батлах тухай” 2024.06.18-ны өдрийн А/49 дугаартай тушаал, ТАБ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн холбогдох байгууллагуудаас аудитад шаардагдах судалгаа, мэдээлэл гаргуулан авч, ирүүлсэн нотлох зүйл, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг горим арга зүйг



ашиглан “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах”, “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит”, “Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх”, “Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” нийцлийн 7 аудитад 303 шалгагдагчийг хамруулан 94.8 сая төгрөгийн өртөг, 440 хүн/өдөр зарцуулж ажилласан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



7
Аудит гүйцэтгэсэн



303
Байгууллагыг хамруулсан



- Нэг нам, эвсэлээс зарцуулах зардлын дээд хэмжээ - 492.5 сая төгрөг
- Нийт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ - 854.8 сая төгрөг

Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит

Үр ашиг сайжруулах 15 санал	885.9
Зарлага бууруулах 3 санал	1,206.4
Орлого нэмэгдүүлэх 1 санал	925.5

Эхний	Тайлант онд тогтоосон	Хэрэгжсэн	Үлдэгдэл
Сая төгрөгөөр			
1 - 42.0	0 - 0	1 - 42.0	0 - 0
Акт			
31 - 8,810.5	2 - 0	31 - 8,810.5	2 - 0
Албан шаардлага			
49 - 0	6 - 6,040.0	50 - 0	5 - 6,040.0
Зөвлөмж			

Тайлбар: Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо - мөнгөн дүн /сая.төг/ гэсэн дарааллаар харна.

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны жилийн эцсийн статистик мэдээ

4.1 Нийцлийн аудитын үр дүн

Нийцлийн аудитаар тайлант онд нийт 6,040.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2 албан шаардлага, 6040.0 төгрөгийн 6 зөвлөмж өгч, өмнөх оны 42.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 8,810.5 сая төгрөгийн 31 албан шаардлага, 49 зөвлөмж, тайлант оны 1 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, хугацаа болоогүй 2 албан шаардлага, 6,040.0 сая төгрөгийн 5 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

4.2 Нийцлийн аудитын үр нөлөө

Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах”, “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит”, “Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх”, “Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” нийцлийн 7 аудитыг хугацаанд нь гүйцэтгэж тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. Нийцлийн аудитаар 9,061.8 сая төгрөгийн 21 санхүүгийн үр өгөөжийг шалгадагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж ажилласан.

4.3 Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох

“Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” нийцлийн аудитыг гүйцэтгэхдээ АДБООС, Төрийн аудит MNS 6817, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах" тухай 08 дугаар тогтоол, СЕХ-ны 2024.01.25-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 06 дугаар тогтоол, ТАБ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн холбогдох байгууллагуудаас аудитад шаардагдах судалгаа, мэдээлэл гаргуулан авч, ирүүлсэн нотлох зүйл, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан хугацаанд нь гүйцэтгэлээ. Аудитад 5.5 сая төгрөгийн өртөг 28 хүн/өдөр зарцууллаа.



492.5 сая төгрөг
Нам, эвсэл

Аудитын дүн



24 тойрог 854.7 сая төгрөг
Нэр дэвшигч

Сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 2024.06.24-ний өдрийн А/07 дугаартай тушаалаар баталгаажуулж, тушаалыг 2024.06.24-ны өдрийн 429 дугаартай албан бичгээр ЯАГ-ын ГНАГ-т хүргүүлж, open.audit.mn цахим сайтад байршуулсан.



4.4 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах

"Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах" аудитыг АДБООУС, Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024.06.18-ны өдрийн А/49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар"-ын дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримтад үндэслэн хянан баталгаажуулж гүйцэтгэлээ. Аудитад 20.3 сая төгрөгийн өртөг 90 хүн/өдөр зарцууллаа



9 нам, **1** эвсэл

Аудитын дүн



42 бие даан
нэр дэвшигч



МОНГОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМЫН
ДЭД ДАРГА М.ОТГОНБАЯР
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах" аудитыг хугацаанд нь чанартай гүйцэтгэлээ. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн



Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох 9 нам 1 эвсэл, 42 бие даагчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргаж ажиллалаа.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох 38 нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт өгч, дүгнэлтийг нам, эвсэл болон Сонгуулийн хороонд тус тус хүргүүлж ажиллалаа.

Бие даан нэр дэвшигчдийн 40 сонгуулийн мөрийн хөтөлбөрт шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт өгч бие даагч болон Сонгуулийн хороонд тус тус хүргүүлж ажиллалаа. Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх 78 дүгнэлтийг 2024.09.18-ны өдөр audit.mn-д байршууллаа.

4.5 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах

Аудитын дүн

СОНГУУЛЬ
2024

Хандив



Нам, эвсэлд 11 дүгнэлт өгсөн.

"Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах" аудитыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох 11 улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг баталгаажуулж ажилласан.

Хандивын тайлангийн дүгнэлтийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох 11 улс төрийн нам, эвсэлд 2024.08.08-ны өдрийн албан бичгүүдээр хүргүүлж ажиллалаа. Хандивын тайлангийн 11 дүгнэлтийг 2024.09.18-ны өдөр audit.mn-д байршууллаа.



4.6 Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит

"Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийх нийцлийн аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 "Нийцлийн аудитын стандарт", Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх


зэрэг арга зүйг ашиглан хугацаанд нь гүйцэтгэлээ. Аудитад 1.7 сая төгрөгийн өртөг 21 хүн/өдөр зарцууллаа.



Аудитын дүн


Аймгийн сонгуулийн хороонд 1 зөвлөмж өгсөн.

Аудитын тайланг 2024.07.18-ны өдрийн А/11 дугаартай тушаалаар баталгаажуулан мөн өдрийн албан бичгээр ГНАГ, Сонгуулийн хорооны даргад тус тус хүргүүлж ажилласан.



4.7 Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит

"Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийх аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 "Нийцлийн аудитын стандарт", Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан хугацаанд нь гүйцэтгэлээ. Аудитад 5.1 сая төгрөгийн өртөг 27 хүн/өдөр зарцууллаа.



Аудитын тайланг 2024.11.20-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар баталгаажуулж мөн өдрийн албан бичгээр ГНАГ, аймгийн Сонгуулийн хорооны даргад тус тус хүргүүлж ажилласан.

4.8 Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит

"Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит" аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 "Нийцлийн аудитын стандарт", Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан орон нутгийн төсвийн төлөвлөлтийн талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт,

дүн шинжилгээ хийх зэрэг горим арга зүйг ашиглан хугацаанд нь гүйцэтгэлээ. Аудитад 30.6 сая төгрөгийн өртөг 136 хүн/өдөр зарцууллаа.



Аудитын дүн

Орон нутгийн төсвийн төсөлд 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар 5,875.4 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээг хууль, журамд нийцүүлэн зөрчлийг арилгуулан, орлогыг 929.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зарлагыг 1,206.4 сая төгрөгөөр бууруулах, үр ашгийг сайжруулах 885.9 сая төгрөгийн санал, 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгч ажилласан.

Аудитын тайланг 2024.11.25-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталгаажуулан мөн өдрийн албан бичгээр СНАГ, Дорнод аймгийн ИТХ-ын дарга, Дорнод аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлж ажиллалаа.

4.9 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг горим арга зүйг 100 хувь мөрдөн ажиллалаа. Аудитад 11.3 сая төгрөгийн өртөг 48 хүн/өдөр зарцууллаа.

Аудитын дүн



Зардлын тайлан ирүүлсэн




2 нам, 1 эвсэл
204 нэр дэвшигч

Нийт 7 нам, 1 эвслээс 2 нам, 1 эвсэл, 758 нэр дэвшигчээс 204 нэр дэвшигч зардлын тайлангаа ирүүлсэн байна. Данс бүртгүүлээгүй 506 нэр дэвшигч, 5 нам, зардлын тайлан ирүүлээгүй 48 нэр дэвшигчийг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу арга хэмжээг авч ажиллахыг 2024.12.19-ний өдрийн албан бичгээр Дорнод аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын газарт тус тус хүргүүлж ажиллалаа.

Аудитын тайланг 2024.12.19-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар баталгаажуулж, ҮАГ-ын ГНАГ-т хүргүүлж, 2024.12.20-ны өдөр audit.mn цахим сайтад байршуулсан.

5. ДОТООД АЖИЛ

5.1 Сургалт



МУЕА-ын "Төрийн аудитын байгууллагын сургалт, хөгжлийн 2023-2027 оны стратегийг батлах тухай" 2023 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан "Сургалт хөгжлийн стратеги", ТАБ-ын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө зэрэгтэй уялдуулан аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагад нийцсэн нийт 5 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусган ТАГ-ын дотоод сургалтын төлөвлөгөөг 2024.02.16-нд баталж ажиллалаа.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант онд нийт 5 сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

Дотооддоо зохион байгуулах сургалт-3

1. Аудиторын арга зүй, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах зэрэг аудитыг гүйцэтгэхэд зориулж "Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль-2024" сэдэвт сургалтыг 2024.06.25-нд;

2. "Аудитын стандарт дүн шинжилгээний аргууд" сэдэвт сургалтыг 2024.12.05-нд;

3. МУЕА-ын 2023 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгын хүрээнд "Аудитын чанарын хяналт" сэдэвт сургалтыг 2024.09.30-нд тус тус зохион байгуулсан.

Бусад байгууллагаас зохион байгуулах сургалт-2

1. "Авилгаас ангид төрийн алба" сэдэвт сургалтын хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авлигатай тэмцэх үйл ажиллагааг танилцуулах, ашиг сонирхлын зөрчил, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх" сургалтад 2024.12.03-04-ний өдрүүдэд;

2. Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан "Худалдан авах ажиллагааны тухай хууль, түүний нэмэлт өөрчлөлт" сэдэвт сургалтад 2024.09.24-нд нийт албан хаагчид хамрагдсан.

Дотоод сургалтын жилийн тайланг 2024.12.06-нд СТГ-ын сургалт судалгааны хэлтсийн шинжээч Б.Батнямын цахим хаягаар хүргүүлж ажиллалаа.

ҮАГ-аас хийсэн сургалт

Төрийн аудитын байгууллагын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан аудитын арга зүйтэй холбоотой-12, цахим системтэй холбоотой-5, МҮЕА-ын баталсан журмын хэрэгжилттэй холбоотой-7, ТАБ-ын аудиторруудын 4 цахим сургалт, нийт 28 сургалтад давхардсан тоогоор 164 албан хаагчид хамрагдсан байна.

Бусад сургалт

Тайлант онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр танилцуулах”, аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан “2023 оны эрүүгийн зөрчлийн мэдээлэл”, аймгийн ГБХХГ-аас зохион байгуулсан “Гэр бүлийн өдөрлөг”, “Хүний хөгжил ба хүүхдийн хөгжил”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага”, Дорнод аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан “Монгол Улсын кибер аюулгүй байдлын нөхцөл байдал”, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас зохион байгуулсан Хөдөлмөрийн дотоод журам /Ажлын байрны дарамт, хүчирхийллийн талаарх мэдлэг ойлголт, хандлагыг тандах судалгаа/ зэрэг нийт 7 сургалтад давхардсан тоогоор 60 албан хаагчид хамрагдсан.

5.2 Харилцагч талуудын хамтын ажиллагаа



Тайлант хугацаанд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан нийт 230 шалгагдагч байгууллагаас санал дүгнэлт өгсөн нийт 103 байгууллагад дүгнэлт, аудитын тайланг хүргүүлж ажилласан. Өмнөх оны аудитын шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй ТШЗ, ТТЗ, төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ-ын нийт 13 удирдлагуудад 141.3 сая төгрөгийн хариуцлага тооцуулах албан шаардлагыг дээд шатны төсөв захирагчдад хүргүүлж ажиллалаа. Тайлант оны эхэнд аудитыг гүйцэтгэх баг бүрэлдэхүүн, гэрээгээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх хувийн аудитын компани болон төсвийн захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан аудитыг нээж, аудитад баримтлах бодлого чиглэлийг танилцуулж, аудитын үед хэрхэн хамтарч ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар шалгагдагч байгууллагууд аудитын үйл ажиллагааг дэмжиж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрөхөд эерэг үр дүн гарч байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн аудитын нээлтийг төсөв захирагч бүрээр хийж, ТАБ-аас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, Төрийн аудитын тухай хуульд орсон өөрчлөлт, ТАБ-ын 2024 онд дэвшүүлсэн зорилтыг танилцуулж ажиллалаа. ТШЗ-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнг 2024.02.26-нд, Төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ-ын аудитын дүнг 2024.03.25-нд, ТТЗ-ийн аудитын дүнг 2024.04.02-нд шалгагдагч байгууллагыг оролцуулан танилцуулж ажиллалаа. Мөн “Улс, орон нутгийн

төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитын нээлтийг 2024.01.24-нд, хэлэлцүүлгийг 2024.05.15-нд, "Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал, үр дүн, үр нөлөө" сэдэвт аудитын нээлтийг 2024.05.21-нд танхим болон онлайнаар, "Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын нээлтийг 2024.09.03-нд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газрын удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан танхимаар, Санхүүгийн тайлангийн завсрын аудитын нээлтийг 2024.09.06-нд завсрын аудитад хамрагдах төсвийн захирагч нарыг оролцуулан онлайн болон танхимаар, "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын нээлтийг 2024.09.06-нд Дорнод аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдыг оролцуулан танхим болон онлайн хосолсон хэлбэрээр, хэлэлцүүлгийг 2024.11.20-нд холбогдох албан тушаалтныг байлцуулан танхимаар, "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын нээлтийг 2024.09.10-нд, хэлэлцүүлгийг 2024.10.23-нд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан танхимаар, "Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" аудитын нээлтийг 2024.11.21-нд, хэлэлцүүлгийг 2024.11.25-нд ЗДТГ-ын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон нийгмийн бодлогын хэлтсийн дарга нарыг оролцуулан танхимаар тус тус зохион байгуулж, мэдээллийг тухай бүр орон нутгийн ТВ болон байгууллагын цахим хуудсаар олон нийтэд түгээж ажиллалаа.

Сар шинийн "Амар байна уу" нэвтрүүлэгт оролцож орон нутгийн Жаран ТВ-д 2024.02.07-ны өдөр Төрийн аудитын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, ТАБ-ын стратеги төлөвлөгөө, бодлого, өмнөх жилүүдэд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, 2024 оныг "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" болгон зарласныг иргэд олон нийтэд сурталчилж ажилласан. Зорилтот жилийн үр дүнг хангах зорилгоор харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр "Далайд дусал нэмэр", "Аудит ард түмний амьдралд" зэрэг иргэд, олон нийт хяналтаа хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээллийг түгээж ажилласан. "Аудит ард түмний амьдралд өдөрлөгөөр нийт 9 төрийн байгууллагаар 2024.06.06-07-ны өдрүүдэд очиж ТАБ-ын үйл ажиллагаа, үр дүн, ТАБ-аас 2024 оны зорилтыг "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" гэж тодорхойлсон талаар 195 албан хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, 2025 оны аудитын сэдвийн талаар нийт 213 иргэдийн саналыг авч ажиллалаа.

Орон нутгийн хэмжээнд арилжааны банкнууд, Татварын ерөнхий газар, улс төрийн 21 нам эвсэл, орон нутгийн ТВ, сонин, хэвлэл мэдээллийн 10 байгууллага болон төрийн, төрийн бус байгууллагуудаас анхдагч болон хоёрдогч мэдээллийг байнга авч холбогдох аудитад боловсруулан ашиглаж хэвшсэн. Гүйцэтгэл, нийцлийн болон санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтаас төсөв, хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, Сангийн яамны сайтаас шалгадагч байгууллагын дансны хуулга зэргийг авч судалгаа, шинжилгээнд ашиглаж байна.

Цахим сайтын холбоос:

- Сангийн яамны цахим сайт www.mof.gov.mn
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим сайт www.open.data.burtgel.gov.mn

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь өөрийн <https://www.facebook.com/Dornod.audit> хуудсыг ажиллуулж тайлан мэдээг иргэдэд хүргэж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг ил тод байршуулан, иргэдээс аудитын сэдвийн саналын судалгаа авч 2024 онд гүйцэтгэх гүйцэтгэлийн 1, нийцлийн 1 аудитын саналыг 2024.06.27-ны өдрийн 434 дугаартай албан бичгээр УАГ-ын АНУЗГ-т хүргүүлж ажилласан.

Мөн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар 2024 онд 122 мэдээ, мэдээлэл байршуулж 55,089 иргэний хандалт авсан байна.

5.3 Мэдээлэл сурталчилгаа



ТАБ-ын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийг бодит мэдээллээр хангах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- ТШЗ-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнг 2024.02.26-нд аймгийн Засаг даргын шуурхай хуралдаанд, Төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ-ын аудитын дүнг 2024.03.25-нд ТТЗ-ийн аудитын дүнг 2024.04.02-нд, "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитын нээлтийг 2024.01.24-нд, хэлэлцүүлгийг 2024.05.15-нд, "Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал, үр дүн, үр нөлөө" сэдэвт аудитын нээлтийг 2024.05.21-нд танхим болон онлайнгаар, "Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын нээлтийг 2024.09.03-нд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газрын удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан танхимаар, Санхүүгийн тайлангийн завсрын аудитын нээлтийг 2024.09.06-нд завсрын аудитад хамрагдах төсвийн захирагч нарыг оролцуулан онлайн болон танхимаар, "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын нээлтийг 2024.09.06-нд Дорнод аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдыг оролцуулан танхим болон онлайн хосолсон хэлбэрээр, хэлэлцүүлгийг 2024.11.20-нд холбогдох албан тушаалтныг байлцуулан танхимаар, "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын нээлтийг 2014.09.10-нд, хэлэлцүүлгийг 2024.10.23-нд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан танхимаар, "Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" аудитын

нээлтийг 2024.11.21-нд, хэлэлцүүлгийг 2024.11.25-нд ЗДТГ-ын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нарыг оролцуулан танхимаар тус тус хийж орон нутгийн ТВ болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж ажиллалаа. Аймгийн ИТХ-ын дарга, төлөөлөгчид болон Засаг дарга нарт 2024.12.20-ны өдөр Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, АНТАГ-аас жил бүр гүйцэтгэх аудитын зохион байгуулалт, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтийг танилцууллаа. Жил бүр ТАГ-ын үйл ажиллагааны үр дүнг орон нутгийн ТВ-ээр сурталчилж ирсэн. Дорнод ДАТА студитэй хамтран 2024 оны ТАГ-ын үйл ажиллагааны үр дүнг сурталчилж ажилласан.

- Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудас болон орон нутгийн Дорнод сонин audit.mn сайтаар аудитын нээлт, явц, дүн болон цаг үеийн шинж чанартай нийт 122 мэдээлэл түгээж 55,089 иргэний хандалт авсан байна.
- Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх заавар”-ын хавсралт-2-ын дагуу 103 байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайланг бэлтгэн нууцын 6 байгууллагуудаас бусад 97 байгууллагын тайлан болон “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”, “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”, “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” аудитаар Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон 2024.06.24-ний өдрийн А/07 дугаартай тушаал, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах” аудитаар Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх 78 дүгнэлт, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах” аудитаар хандивын тайлангийн 11 дүгнэлт, “Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүн”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”, “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд хийх аудит”, “Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит”, “Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын хураангуй тайланг тус тус “Open.audit.mn” цахим портал сайтад байршуулсан.

5.4 Албан харилцаа



Тайлант оны санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 229 хариутай бичиг ирснийг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн.

ХХНЖ-ын дагуу нийт 35 баримтыг цахим болон цаасан суурьтайгаар хүлээн аваад байна.

Хүний нөөцтэй холбоотой судалгаа, мэдээ тайланг УАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу цаг тухай бүрд гарган заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үүнд:

- Албан хаагчдын цалингийн тооцооллыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмын дагуу ТАЦНС-ээр гаргаж, цаг тухайд нь олгож байна.
- Газрын 2024 оны улирал бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.
- Монгол Улсын Ерөнхий аудиторын "А" тушаалаар өгсөн үүрэг даалгавар, Удирдах ажилтны зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, АНТАГ-ын удирдлагын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг улирал бүр, Төрийн аудитын газрын үйл ажиллагааны 14 хоногийн хураангуй тайланг холбогдох газруудад хугацаанд нь тус тус хүргүүлж ажилласан.
- Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 онд цаасаар нийт 1325 удаагийн 7960 хуудас, цахимаар 1325 удаагийн 7960 хуудас албан бичиг эргэлтэд орсон байна. Үүнээс явсан бичиг 666 /цаас болон цахим/, ирсэн бичиг 659 /цаасан болон цахим/ байна. Өргөдөл, гомдол 19, А тушаал 24, Б тушаал 16, төлбөрийн акт 64, албан шаардлага 168, хурлын тэмдэглэл 9 байна.

5.5 Өргөдөл гомдол



Тайлант онд ирсэн нийт 19 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг авле программд хугацаанд нь бүртгэж, хариутай нийт 16 өргөдөл, гомдол, саналыг хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа. Үүнээс албан хаагчдаас ирсэн 13 хүсэлт, ДБЭХС ТӨХК-тай холбоотой нэрээ нууцалсан 2 өргөдөлтэй холбоотой асуудлыг аудитын тайланд тусгаж хугацаанд нь шийдвэрлэсэн. ДБЭХС ТӨХК-ний Сүхбаатар ЦТС салбартай холбоотой 1 өргөдлийн хариуг 2024.05.16-ны өдрийн 358 дугаар албан бичгээр хүргүүлж шийдвэрлэсэн. Байгууллагын нас барсан ахмад настны ар гэрээс нас барсны буцалтгүй

тусламжийн мөнгөн тэтгэмж гаргуулах тухай ирүүлсэн өргөдлийг 2024.09.04-ний өдрийн 565 дугаартай албан бичгээр Тамгын дарга, хувийг УАГ-ын ахмадын хорооны даргад уламжилж шийдвэрлүүлсэн. "Асралт үйлс" ӨЭМТ-тэй холбоотой өргөдлийн хариуг 2024.12.10-нд, "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-д хийх аудитын явцад ирсэн 1 өргөдлийн хариуг 2024.12.05-нд тус тус холбогдож хүргүүлсэн.

5.6. Нууцын хадгалалт хамгаалалт



Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдлөг болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/108 дугаар тушаалаар батлагдсан төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмын дагуу 2024 оны 01 дүгээр сард нийт албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авсан.
- Тайлант онд нууцад хамаарах байгууллагуудын /7 цэргийн анги, Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар/ санхүүгийн тайлан холбогдох материалуудыг нууц хамгаалах сэйфэнд хадгалж байна.
- ТАГ-аас 2023 онд Төрийн албаны нууц, хадгалалт хамгаалалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг 2024.01.08-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ТЕГ-ын Дорнод аймаг дахь Тагнуулын газрын даргад хүргүүлж ажилласан.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох 8 нам 1 эвслийн 65 мөрийн хөтөлбөр, хандивын тайланг журмын дагуу хуулийн хугацаанд нууцын ажилтан хүлээн авч нууцын баримт хадгалах сэйфэнд хадгалж ажилласан.

5.7 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх



Ажилтнуудын ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулж, мэдүүлгийг meduuleg.iaac.mn сайтад 2024.02.15-ны дотор бүрэн оруулж баталгаажууллаа.

ТАГ-ын ХАСХОМ гаргадаг нийт 10 албан хаагчдын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын meduuleg.iaac.mn сайтад 2024.01.31-ний дотор гаргуулж баталгаажуулалтын хуудсанд гарын үсэг зуруулж авч Авлигатай тэмцэх газарт тайлан хүргүүлж ажилласан. Санхүүгийн тайлангийн аудитаар ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргасан 1, "Орон

нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө"-д хийх гүйцэтгэлийн аудитаар ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргасан 1 албан хаагчийн мэдэгдлийг Авлигатай тэмцэх газрын meduuleg.iaas.mn сайтад байршуулж ажилласан. Шинээр томилогдсон шинжээчийн ХАСУМ болон ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд meduuleg.iaas.mn сайтад баталгаажуулж ажилласан. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам"-ыг нийт албан хаагчдад 2024.05.14-ний өдөр танилцуулж "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ийг мэдүүлэг гаргагчаас хуульд заасны дагуу хэрхэн гаргах талаар сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулж ажилласан.

"Төрийн аудит иргэдийн амьдралд-2024" өдөрлөгийн хүрээнд 9 байгууллагын 200 гаруй албан хаагчдад авлигын эсрэг үйл ажиллагааг таниулж, 300 гаран гарын авлагыг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа. Авлигатай тэмцэх газраас 2024.12.03-04-ний өдрүүдэд зохион байгуулсан "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр" сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, подкаст зэрэг нийт 41 мэдээллүүдийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын фэйсбүүк хуудсанд хуваалцсан нь өмнөх улирлаас 25 мэдээллээр нэмэгдсэн байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбоотой зохион байгуулсан "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог ханган хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан постеруудыг цахим хуудсанд түгээн ажиллаж байна.

5.8. Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд:



Цаг үеийн шинжтэй хийгдсэн нэмэлт ажлуудыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.

- Санхүүгийн тайлангийн аудитын шалгагдагч 235 байгууллагын шинэчилсэн мэдээллийг org.audit.mn цахим системд оруулж ажилласан.
- Эрсдэлийн удирдлагын газраас ирүүлсэн маягтын дагуу тайлант оны Санхүүгийн тайлангийн аудитаар 143 байгууллагад хүргүүлсэн 51 төлбөрийн акт, 138 албан шаардлага, 179 зөвлөмж, 13 хариуцлага тооцох албан шаардлагын биелэлтийг гаргаж нотлох баримт болон, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024.11.05-нд хүргүүлж ажилласан.

5.9. Мэдээллийн технологи



Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын аюулгүй байдлыг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Шинээр суурилуулсан 10 суурин 1 зөөврийн компьютерыг домайн хаягт холбосон.
- Серверийн төхөөрөмжийн байршлыг өөрчилж холболтыг шинэчилж, уулзалтын өрөөнд байршуулсан.
- Тайлант онд гүйцэтгэл, нийцлийн аудитын систем, аудитын сэдэв сонголтын модуль, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модуль, статистик мэдээний stat.audit.mn системийн хөгжүүлэлттэй холбоотой саналыг ҮАГ-ын МТТ-ийн захирал А.Уянга-эрдэнэд 2024.06.20-н өдрийн 425 дугаартай албан бичгээр хүргүүлж ажиллалаа

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татвар болон нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам зааврын дагуу аккрузль сууриар илэрхийлэн “Юникус” программаар гарган ажиллаж байна. Төрийн аудитын газар нь Шилэн дансны цахим сайтад сар бүр оруулах 48, хагас жилээр оруулах 4, жил бүр оруулах 5, тухай бүр оруулах 108 нийт 165 мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулан ажилласан.

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар, сар улирлын хуваарийн дагуу зарцуулж, тайлант онд 987.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 979.0 сая төгрөгийг зарцуулж, 99.15 хувийн гүйцэтгэлтэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Санхүүжилийн орлого	987,425.00	979,037.60	8,387.41	99.15
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	662,000.00	654,095.66	7,904.34	98.81
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,750.00	82,419.17	330.83	99.60
Хангамж, бараа материалын зардал	31,000.00	31,000.00	-	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	115,300.00	115,300.00	-	100.00
Томилолт, зочны зардал	17,330.00	17,330.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,283.20	40,130.97	152.23	99.62
Бараа үйлчилгээний бусад зардал	5,761.80	5,761.80	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,000.00	33,000.00	-	100.00

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж ирсэн. Байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн хугацаанд гаргаж УАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газар болон Мишээл-Од аудит ХХК-руу хүргүүлж, 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж "ӨӨРЧЛӨЛТГҮЙ" санал дүгнэлт авч ажилласан. МУЕА-ын 2020 оны А/101 дугаартай тушаалаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу ТАГ-ын 2024 оны Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөөг баталж, 2024.01.15-ны өдрийн 103 дугаартай албан бичгээр МУЕА-т хүргүүлж ажилласан. Газрын 2025 оны төсвийн төслийг эдийн засгийн ангилал бүрээр тооцож 2024.06.10-ны өдрийн 365 дугаартай албан бичгээр МУЕА-т хүргүүлсэн.

7. ДҮГНЭЛТ



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилтыг "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" гэж тодорхойлсны дагуу 4 зорилт, 11 дэд зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж ирсэн. Төрийн аудитын газар нь 2024 онд 242 аудитыг гүйцэтгэж, үүнээс Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төсөв захирагчдын төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 103 бие даасан дүгнэлт гаргаж, 127 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Гүйцэтгэлийн 5 аудитад 250, нийцлийн 7 аудитад 303 шалгагдагч этгээдийн үйл ажиллагааг тус тус хамруулж ажиллалаа.

Тайлант онд гүйцэтгэсэн аудитаар нийт 111,816.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 274.9 сая төгрөгийн зөрчилд 64 төлбөрийн акт тогтоож, 37,264.0 сая төгрөгийн зөрчилд 168 албан шаардлага, 19,902.4 сая төгрөгийн зөрчилд 293 зөвлөмж, 141.3 сая төгрөгийн 13 сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгч ажиллалаа. Тайлант онд

хэрэгжих аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь хангуулан, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 2 ширхэг 1,186.1 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилж ажилласан.

Тайлант онд 36,762.6 сая төгрөгийн 182 санхүүгийн, 16 санхүүгийн бус үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 37.5 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 14 төгрөгөөр буюу 59.6 хувиар өссөн байна.

8. ШИНЭ САНААЧИЛГА



1. Аудитын тайланг иргэд, олон нийтэд түгээн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар бие даасан дүгнэлт өгсөн 103 байгууллага, “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын 1 нийт 103 хураангуй тайланг МҮЕА-ын 2022 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Харилцагч талуудад зориулсан аудитын хураангуй тайлан бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж нууцын 6 байгууллагаас бусад 97 хураангуй тайлан, 1 “Татгалзсан” дүгнэлт, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”, “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”, “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” аудитаар Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон 2024.06.24-ний өдрийн А/07 дугаартай тушаал, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах” аудитаар Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх 78 дүгнэлт, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад, иргэд хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлан баталгаажуулах” аудитаар хандивын тайлангийн 11 дүгнэлт, “Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүн”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”, “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд хийх аудит”, “Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит”, “Дорнод аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын хураангуй тайланг тус тус “Нээлттэй аудит” мэдээллийн портал сайтад байршуулж, “Санхүүгийн тайлангийн аудит”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал, үр дүн, үр нөлөө”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” зэрэг аудитаар инфографик хийж олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

2. Сайн туршлага

"Аудит ард түмний амьдралд" өдөрлөгийг сүүлийн 3 жил дараалан уламжлал болгон зохион байгуулж байна. ТАБ-ын 2024 оны зорилтыг "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" гэж тодорхойлсны дагуу харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийг нийт 9 байгууллагын 195 албан хаагчдад уулзалт, ярилцлага зохион байгуулж ажиллалаа. Өдөрлөгийн үеэр 2025 оны аудитын сэдвийн талаар нийт 213 иргэд саналаа ирүүлсэн. Дарга, тэргүүлэх аудитор Азийн аудитын дээд байгууллагуудын 16-р чуулганд 2024 оны 9-р сарын 24-27-ны өдрүүдэд оролцож чуулганаар олж авсан мэдээлэл болон Дэлигийн тунхаглалын агуулгыг орчуулан албан хаагчдадаа түгээж ажиллалаа. Тогтвортой хөгжлийн зорилтод аудит хийх замаар засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудад хийх аудитаар дамжуулж засаглалд үр өгөөжийг бий болгоход анхаарч хүртээмжтэй, тэгш, шударга нийгмийг бий болгох, орон нутгийн засаглалд аудит гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, бүс нутгийн чиглэлээр аудитыг гүйцэтгэх, өөр өөр түвшний гүйцэтгэлийн үзүүлэлттэй нэгжүүдийн сайн туршлагыг хуваалцах, орон нутгийн аудитын аргачлалыг сайжруулах талаар саналыг удирдлагуудад дэвшүүлэхээр ажиллаж байна. МУЕА-ын орлогчийн баталсан "Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллах ажлын удирдамж"-ийн дагуу 2024.11.04-05-ний өдрүүдэд, "Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газраас Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллах ажлын удирдамж"-ийн дагуу 2024.11.18-19-ний өдрүүдэд тус тус хамтран ажиллаж, харилцан туршлага солилцлоо.

3. Спортын уралдаан тэмцээнд амжилттай оролцов.

Сүхбаатар аймагт 2024.05.02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Зүүн бүсийн сургалтад нийт албан хаагчид зохион байгуулалт сайтай оролцлоо. Аудиторуудын дунд зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд багаараа 1-р байр, дартсын эрэгтэй ганцаарчилсан төрөлд 1, 2-р байр, эмэгтэй ганцаарчилсан төрөлд 3-р байр, ширээний теннисний эрэгтэй ганцаарчилсан төрөлд 1-р байр, эмэгтэй ганцаарчилсан төрөлд 3-р байрыг тус тус эзэллээ.

Дорнод аймгийн Дартсын холбооноос 2024.06.26-нд зохион байгуулсан "Чансаа" тэмцээнд ахлах аудитор Я.Зориг 4-р байр, Статистикийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан шатрын тэмцээнд аудитор С.Энхбаатар 2-р байр, Г.Ганбилэг 3-р байр тус тус эзэллээ. "Санхүү, эдийн засгийн алба үүсэн байгуулагдсаны 113 жил"-ийн ойг тохиолдуулан аймгийн Санхүү төрийн санхүүгийн хэлтсээс 2024.11.09-10-ны өдрүүдэд зохион байгуулсан спортын арга хэмжээнд хамт олноороо амжилттай оролцсон.

4. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжрууллаа.

Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөлийг сайжруулж орон нутгийн хөрөнгө оруулалт болон байгууллагын батлагдсан төсвөөс бүх албан хаагчдын ширээ сандал, компьютер, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж, сургалт, амралт, архив, коридор, оффисын өрөөг засварлан тохижуулж, ажиллалаа. Нийт албан хаагчдыг эрт илрүүлгийн Нура Монголиа төвтэй гэрээ байгуулан шинжилгээнд хамруулсан. Орон нутагт өөрийн хүчээр ДБЭХС ТӨХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх хүсэлтийг УАГ-т уламжилж шийдүүлснээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэн, аудитын төлбөрийн орлогоос Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн аудитын байгууллагын "Хөдөлмөрийн

дотоод журам"-д заасны дагуу 5 албан хаагчдад тус бүр 10 сая төгрөгийн орон байраар хангах болон нөхцөл сайжруулахад нь дэмжлэг үзүүлээ.

Ажиллах нөхцөлийг сайжруулсан болон эрүүл мэндийн үзлэгт хамруулсан орон байраар хангах болон нөхцөл сайжруулахад нь дэмжлэг үзүүлсэн явдалд албан хаагчид талархаж, сэтгэл ханамжийн түвшин өсөж, ажлын бүтээл нэмэгдсэн үр дүн гарч байна.

9. САНАЛ



Төрийн аудитын байгууллага, түүний дотор аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын чиг үүрэг, үйл ажиллагаанд бий болгох хэрэгцээ шаардлагын талаарх санал:

1. Орон нутаг дахь Төрийн аудитын газрууд нь аймгийн ИТХ-ын хуралдаанд төсөв мөнгөтэй холбоотой асуудал хэлэлцэх үед зөвлөх эрхтэй оролцдог байх нь Төрийн аудитын тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд үр дүн үзүүлэхээр байна. Ялангуяа төсөвт тодотгол хийх үед санал дүгнэлт өгөх нь Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зорилгыг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна. Иймээс Орон нутаг дахь Төрийн аудитын газруудын өмнө хэрэгжүүлдэг байсан бодлогын чиг үүргийг сэргээх саналыг удаа дараа хүргүүлж байна.
2. ТАБ-аас нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх аудитыг бүсийн хэмжээнд нэгтгэн гүйцэтгэх, тайлагнах зохион байгуулалтыг бий болгох. Ингэснээр аудитын байгууллагын аудитын эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Мөн түүнчлэн азийн аудитын дээд байгууллагуудын 16-р чуулган дээр “Бүс нутгийн аудит” буюу бодлогыг онцлон ОХУ-аас илтгэл, танилцуулгыг хийж байсан.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ойрын төлөвлөгөөнд тусгуулах санал, санаачилга:

Нэгдсэн удирдамжтай аудитаар нэгдсэн тайланд тусгуулахаар хүргүүлсэн саналын шийдвэрлэлтийг эргэж мэдээлдэг байх.

